



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Номдизель ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/036/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Өмнөговь аймаг</p> <p>2026 он</p>	<p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Г.Шижирболд Утас: 70533552 Цахим хаяг: umnugovi@audit.gov.mn</p> <p>Азуре хүлүг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Мөнхбаяр Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.16 № 303

танай _____ -ны № _____ -т

НОМДИЗЕЛЬ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.НАРАНБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Номдизель ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй "Нутгийн дэм" хөтөлбөрт хамрагдаж, байгууллагын албан хаагчдад нийт 67,780.1 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Аудитын гол асуудал

Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн хөрөнгө оруулалтаар 60,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл нийлүүлэгдсэн бол Номгон сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр 49,838.9 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус үйлдвэрийн газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгагдсан асуудал нь хамаарахгүй болно.

4626050440

Г12 Бичиг хэрэг/2026/мнСТА-н дүгнэлт/Төрийн Дарга

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
2	Эргэлтийн хөрөнгө	-	-
3	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	215,717,875.18	227,165,710.83
4	Дансны авлага	-	-
5	Татвар, НДШ-ийн авлага	885,680.45	461,943.01
6	Бусад авлага	-	-
7	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
8	Бараа материал	27,629,431.00	28,876,708.00
9	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
13	Эргэлтийн хөрөнгийн дүн	244,232,986.63	256,504,361.84
14	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
15	Үндсэн хөрөнгө	8,689,263,392.74	8,245,886,335.37
23	Биет бус хөрөнгө	5,409,999.97	5,240,000.00
24	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,694,673,392.71	8,251,126,335.37
25	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,938,906,379.34	8,507,630,697.21
26	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
27	Өр төлбөр	-	-
28	Богино хугацаат өр төлбөр	-	-
29	Дансны өглөг	-	-
31	Татварын өр	-	271,998.80
32	НДШ-ийн өглөг	-	-
41	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	271,998.80
42	Урт хугацаат өр төлбөр	-	-
43	Урт хугацаат зээл	-	-
46	Бусад урт хугацаат өглөг	8,369,686,463.65	7,934,104,194.98
48	Урт хугацаат өр төлбөрийн дүн	8,369,686,463.65	7,934,104,194.98
49	Өр төлбөрийн нийт дүн	8,369,686,463.65	7,934,376,193.78
50	Эздийн өмч	-	-
51	Өмч: а) төрийн	591,173,073.75	591,173,073.75
56	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	45,157,777.01	45,157,777.01
59	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(67,110,935.07)	(63,076,347.33)
61	Эздийн өмчийн дүн	569,219,915.69	573,254,503.43
62	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	8,938,906,379.34	8,507,630,697.21

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	714,127,140.23	803,780,730.90
2	Борлуулалтын өртөг	806,204,159.94	1,194,920,440.72
3	Нийт ашиг	(92,077,019.71)	(391,139,709.82)
4	Түрээсийн орлого	-	677,090.89
5	Хүүний орлого	2,190,374.94	3,721,402.41
8	Бусад орлого	384,858,258.19	574,524,174.86
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	181,950,447.65	153,453,241.95
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	2,705,240.00	500,000.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	93,807,275.68	26,362,157.01
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг алдагдал	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	16,508,650.09	7,467,559.38
19	Орлогын татварын зардал	11,302,116.58	3,432,971.64
20	Татвар дараах ашиг (алдагдал)	5,206,533.51	4,034,587.74
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	5,206,533.51	4,034,587.74
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
27	Орлогын нийт дүн	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон
/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2024 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	591,173,073.75	45,157,777.01	(67,110,935.07)	569,219,915.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	-	4,034,587.74	4,034,587.74
2025 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	591,173,073.75	45,157,777.01	(63,076,347.33)	573,254,503.43

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2	Мөнгөн орлогын дүн (+)	836,047,140.94	1,002,757,034.79
8	Бусад мөнгөн орлого	836,047,140.94	1,002,757,034.79
9	Мөнгөн зарлагын дүн (-)	751,309,405.58	991,309,199.14
10	Ажиллагчдад төлсөн	246,360,472.00	367,303,325.00
11	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	83,238,411.16	120,173,449.83
12	Бараа материалын худалдан авахад төлсөн	330,480,727.94	403,692,720.31
13	Ашиглалтын зардалд төлсөн	111,850.00	117,500.00
16	Татварын байгууллагад төлсөн	91,117,944.48	100,022,204.00
19	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	84,737,735.36	11,447,835.65
20	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
21	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
22	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
23	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
24	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
25	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
26	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
30	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
31	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
37	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
38	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
39	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
40	Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
42	Төрөл бүрийн хандив	-	-
44	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
45	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
46	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
50	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
51	Валютын ханшийн зөрүү	-	-
52	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	84,737,735.36	11,447,835.65
53	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	130,980,139.82	215,717,875.18
54	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	215,717,875.18	227,165,710.83

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Тайлант оны (2025)			
		2025 Батлагдсан төлөвлөгөө	2025 Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Нийт борлуулалтын орлого	1,379,658,146.09	1,382,703,399.06	3,045,252.97	100.2
	Үйл ажиллагааны борлуулалтын орлого	812,825,789.42	815,619,639.98	2,793,850.56	100.3
1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих/ Дулаан борлуулсны орлого	603,792,240.06	604,112,292.65	320,052.59	100.1
2	Ус хамгамж, ариутгах татуурга/	49,885,000.00	50,058,270.00	173,270.00	100.3
3	Хот тохижилт, үйлчилгээ	147,687,436.36	149,610,168.25	1,922,731.89	101.3
4	Түрээсийн орлого	677,091.00	677,090.89	(0.11)	100.0
5	Бусад орлого үйл ажиллагааны	10,784,022.00	11,161,818.19	377,796.19	103.5
1	Банкны хүүний орлого	3,470,000.00	3,721,402.41	251,402.41	107.2
2	Бусад орлого (Нутгийн дэм)	67,780,088.00	67,780,088.00	-	100.0
3	Бусад орлого (Хойшлогдсон хөрөнгийн орлого)	495,582,268.67	495,582,268.67	-	100.0
	НИЙТ ЗАРЛАГА	1,377,821,402.56	1,375,235,839.68	(2,585,562.88)	99.8
1	Түүхий эдийн зардал	73,263,607.56	77,989,489.40	4,725,881.84	106.5
2	Ажилчдын цалин	486,372,858.00	486,093,497.00	(279,361.00)	99.9
3	НДШ,ЭМД	66,126,009.05	66,015,815.83	(110,193.22)	99.8
4	Элэгдлийн зардал	49,911,617.58	49,909,813.66	(1,803.92)	100.0
5	Хойшлогдсон хөрөнгийн элэгдэл	495,586,060.21	495,582,268.67	(3,791.54)	100.0
6	Албан томилот	3,520,000.00	3,520,000.00	-	100.0
7	Шуудан холбоо	3,000,000.00	1,424,882.00	(1,575,118.00)	47.5
8	Банкны шимтгэл	120,600.00	117,500.00	(3,100.00)	97.4
9	Мэргэжлийн ажлын ү/хөлс	5,820,000.00	5,820,013.00	13.00	100.0
10	Сургалтын зардал	966,000.00	965,909.00	(91.00)	100.0
11	Цахилгаан	88,033,646.15	88,033,646.30	0.15	100.0
12	Шатахуун	15,686,860.00	15,639,800.81	(47,059.19)	99.7
13	Хөдөлмөр хамгаалал	13,255,000.00	13,234,879.00	(20,121.00)	99.8
14	Бичиг хэрэг	2,192,732.00	2,192,733.00	1.00	100.0
15	Сэлбэг	23,500,000.00	20,048,354.00	(3,451,646.00)	85.3
16	Хангамжийн материал	15,500,000.00	14,080,826.00	(1,419,174.00)	90.8
17	Албан татвар төлбөр хураамж	3,085,855.00	3,085,855.00	-	100.0
18	Бусад зардал	5,018,400.00	4,618,400.00	(400,000.00)	92.0
19	Хүү торгууль	500,000.00	500,000.00	-	100.0
20	Үндсэн хөрөнгө акталсны гарз	26,362,157.01	26,362,157.01	-	100.0
	Нийт зардлын дүн	1,377,821,402.56	1,375,235,839.68	(2,585,562.88)	99.8
	Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	1,836,743.54	7,467,559.38	5,630,815.84	406.6
	Орлогын татварын зардал	183,674.35	3,432,971.64	3,249,297.29	1,869.1
	Татвар дараах ашиг/алддагдал	1,653,069.18	4,034,587.74	2,381,518.56	244.1
	Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал	1,653,069.18	4,034,587.74	2,381,518.56	244.1

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0.3 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад 0.3 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- ААНОАТ-ын өглөг 0.3 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар 5.8 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 5.8 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 10.7 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага тогтоогоогүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 5.8 сая төгрөгийн дүн бүхий 21 ширхэг үндсэн хөрөнгүүдийн үнэлгээг хийж, ашиглах хугацаа, өртгийг шинэчлэн тогтоогоогүй байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 20 дугаар зүйл 20.2 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ" заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" заалт, Сангийн сайдын 2014 оны 249 тоот тушаалд "Хөрөнгөнд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөж буюу үйлчилгээний чадавхыг тухайн байгууллага хүртэх магадлалтай ба хөрөнгийн өртөг эсвэл бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой тохиолдолд үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ нөхсөн боловч үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг нягтлан бодох бүртгэлийн зорилгоор тодорхойлж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр ашиглалтын хугацаа, өртгийг шинэчлэн тогтоох;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй Орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ААНОАТ-ын өглөг 272.0 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй.	1	272.0	1	272.0	-	-	1	272.0	-	-	-	-
	Дүн	1	272.0	1	272.0	-	-	1	272.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 5,845.0 мянган төгрөгийн дүн бүхий 21 ширхэг үндсэн хөрөнгүүдийн үнэлгээг хийж, ашиглах хугацаа, өртгийг шинэчлэн тогтоогоогүй	1	5,845.0	-	-	-	-	1	5,845.0	-	-	-	-
	Дүн	1	5,845.0	-	-	-	-	1	5,845.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Тайлант онд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан барилга, байгууламжийн засвар, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нийт 75,380.0 мянган төгрөгийг шууд гэрээ байгуулж худалдан авалт хийсэн.	1	75,380.0	-	-	1	75,380.0	-	-	-	-
	Дүн	1	75,380.0	-	-	1	75,380.0	-	-	-	-